Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ. Тайлант онд ОБЕГ-ын Хяналт, шалгалтын газраас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газар нь ОБЕГ-ын даргын 2016 оны А/293 дугаар тушаалаар батлагдсан *"Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"*-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Уг НББББББ-ийг баталж, хэрэгжүүлж эхэлсэн 2016 оноос хойш холбогдох хууль, эрхийн актууд, стандартад тодорхой хэмжээний нэмэлт өөрчлөлт орсон тул эдгээр өөрчлөлтүүдэд нийцүүлэн бодлогын бичиг баримтыг шинэчлэн боловсруулах нь зүйтэй юм.

4317143998
МЮА0065 9055436

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан *"Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"*-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 31,920.3 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 34,226.9 | - | (34,226.9) |
| Бараа материал | 1,863,900.1 | 2,353,773.4 | 489,873.3 |
| Үндсэн хөрөнгө | 10,060,446.7 | 9,636,720.6 | (423,726.1) |
| **Нийт хөрөнгө** | **11,958,573.8** | **11,990,494.0** | **31,920.3** |
| Өр төлбөр | 33,826.8 | - | (33,826.8) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 11,924,746.9 | 11,990,494.0 | 65,747.1 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **11,958,573.8** | **11,990,494.0** | **31,920.3** |

Өмнөх оны эцэст тайлагнагдсан 34,226.9 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлага нь тайлант онд бүрэн барагдсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 2,353,773.4 мянган төгрөг болж 489,873.3 мянган төгрөгөөр өссөн байгаа нь төсвийн хөрөнгөөр 796,143.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, систем хоорондын шилжүүлгээр 681,788.9 мянган төгрөгийн бараа материал, бусад байгууллагаас 214,985.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, шатахууны урамшуулал болох 1,938.2 мянган төгрөгийг орлогоор бүртгэсэн болон 938,609.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан, хилийн цэргийн 0101 дүгээр ангид 44,058.1 мянган төгрөгийн, аймгийн ЗДТГ-т 26,536.3 мянган төгрөгийн, систем хооронд 195,778.3 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 17,193,931.7 мянган төгрөг болж 482,145.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 356,966.7 мянган

төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч бүртгэл тайланд тусгасан */196,592.0 мянган төгрөгийн "8 айлын орон сууцыг конторын барилга болгож засварлах" ажлыг хүлээн авсан, "Усны сургалтын төв байгуулах" төсөл, арга хэмжээний тайлант оны 147,575.0 мянган төгрөгийн гүйцэтгэлийг дуусаагүй барилга дансанд бүртгэсэн/* Дэлхийн зөн ОУБ-аас 22,927.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан, систем хооронд 257,200.0 мянган төгрөгийн 3 автомашиныг үнэ төлбөргүй хүлээн авсан болон ТӨБЗГ-ын 2022 оны 16 дугаар тогтоолоор 5 нэр төрлийн 129,748.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг систем хооронд шилжүүлсэн, 25,200.0 мянган төгрөгийн автомашиныг дуудлага худалдаагаар худалдсантай холбоотой байна.

Өмнөх онд үүссэн "Хүчит Сэлэнгэ" ХХК-тай холбоотой 33,826.8 мянган төгрөгийн өр төлбөрийг тайлант онд төлж барагдуулан, өр төлбөргүй тайлагнагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 11,990,494.0 мянган төгрөг болж 65,747.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус газар нь 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,694,067.2 мянган төгрөг, нийт зарлагыг 4,694,067.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчаас хүргүүлсэн төсвийн төслийн саналаас байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 280,978.9 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 9,164.7 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 127,989.8 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 339,901.5 мянган төгрөгөөр, албан томилолтын зардлыг 2,404.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 13,535.0 мянган төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 11,622.0 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал зардлыг 9,403.0 мянган төгрөгөөр зэрэг нийт 794,998.9 мянган төгрөгөөр бууруулж 3,899,068.3 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 370,225.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн зохицуулалт хийсэн байна. */цалингийн сан 33,409.0 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 4,176.0 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 3,572.2 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 342,365.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардал 5,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 11,112.7 мянган төгрөгөөр, нормативт зардал 5,972.9 мянган төгрөгөөр, албан томилолтын зардал 112.2 мянган төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал 581.1 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал зардал 518.2 мянган төгрөгөөр тус тус буурсан/*

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,269,293.7 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,269,293.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,263,561.2 мянган төгрөг буюу 99.9 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байгаа нь нийгмийн даатгалын зардлыг 5,715.9 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын 13.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 4,260,408.9 | 4,254,689.6 | 5,719.3 | 99.9 |
| 2 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 8,884.8 | 8,871.6 | 13.2 | 99.9 |
| | **Нийт** | **4,269,293.7** | **4,263,561.2** | **5,732.5** | **99.9** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т *“нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна”* гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 390,201.2 мянган төгрөгийн орлого төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулсан байна. Үүнд:

- ОБЕГ-аас тайлант онд 110,762.8 мянган төгрөг төвлөрснөөс гал түймэр, гамшиг ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдын томилолтын зардалд 65,576 мянган төгрөг, 5 дугаар ангийн конторын өргөтгөл, төмөр замын засварт 31,974.8 мянган төгрөг, ахмадын хорооны санхүүжилтэд 9,072 мянган төгрөг, бусад зардалд 4,140.0 мянган төгрөгийг зарцуулсан,
- Монголын Гал унтраах техникийн олон төрөлт спортын холбооны 14,815.4 мянган төгрөгийг Гал унтраах техникийн олон төрөлт спортын “Улсын аварга шалгаруулах” тэмцээнийг Сэлэнгэ аймагт зохион байгуулахад,
- Зам тээврийн яамнаас төвлөрүүлсэн 34,226.9 мянган төгрөгийг Улаанбаатар Дархан чиглэлийн авто замын трасст орсон Гал түймэр унтраах, аврах 40 дүгээр анги, 5 дугаар ангийн барилга байгууламжийг буулган шилжүүлэх зардалд,
- Аймгийн Засаг даргын 2022 оны А/50, А/52, А/189 дүгээр захирамжуудаар гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн зардалд 54,585.0 мянган төгрөг, А/82 дугаар захирамжаар 2020-2021 онд коронавируст цар тахлын үеэр ажилласны шагналд 2,000 мянган төгрөг, А/99 дүгээр захирамжаар ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хяналтын цэг ажиллуулах зардалд 30,000 мянган төгрөг, А/287 дугаар захирамжаар үер, усны ослоос урьдчилан сэргийлэх зарим арга

хэмжээний зардалд 14,973.9 мянган төгрөг, А/451 дүгээр захирамжаар гал унтраах автомашины гаалийн татварын зардалд 8,982.9 мянган төгрөг, А/413 дугаар захирамжаар тус газрын 8 айлын орон сууцыг конторын зориулалттай болгож засварлах ажлын зардалд 80,000 мянган төгрөг,

- Аймгийн ИТХ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор гал унтраах багаж худалдан авахад 36,000 мянган төгрөг, өсвөрийн аврагчдын дунд зохион байгуулдаг *"Бэлэн бай"* дэвжээ тэмцээний зардалд 2,540.8 мянган төгрөг, галын аюулаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын зардалд 1,208.5 мянган төгрөгийн,
- Цахимаар зарласан тендерийн баримт бичгийн үнэ 105.0 мянган төгрөг гэх мэт.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д *"Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана"* гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн анхан шатны баримтын бүрдүүлэлт, хөрөнгийн ангилал, мөнгөн кассын үйл ажиллагаатай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газар нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 31/29 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 5,835,974.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 58,359.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд ОБЕГ-ын даргын 2022 оны А/192 дугаар тушаалаар "Төсвийн хэмнэлтийн түр журам"-ыг баталсан бөгөөд тус газар нь дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,*
- *Тээвэр шатахуун, хичээл сургалт үйлдвэрлэлийн зардлыг хэмнэх зорилгоор сургалт, уулзалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан,*
- *Баяр ёслол, тэмдэглэлт өдөр, аялал зугаалга, уралдаан тэмцээн зохион байгуулаагүй,*

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамаарах 33 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад тус хуулийн 15.1.5-д *"төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"* гэсэн заалтыг зөрчиж 1,000.0 мянган төгрөгийн бэлэг дурсгал худалдан авсан зөрчил илэрлээ.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан *"Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"*-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

*Илрүүлэлт:* Шилэн дансанд мэдээлбэл зохих 20 төрлийн 170 мэдээллээс 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт – 3 удаа
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт – 1 удаа
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ – 1 удаа
- Санхүүгийн тайлан – 1 удаа
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл – 3 удаа
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг – 2 удаа
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт – 3 удаа

*Шийдвэрлэсэн нь*: Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалтуудыг зөрчсөн тул холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлж байх зөвлөмж хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4317143998
МЮА0065 9055436

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

*Илрүүлэлт:* Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан боловсруулж, батлуулаагүй, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлээгүй байгаа нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-д *“Захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг шаардлагатай бол техник, эдийн засгийн үндэслэлийн хамт дараа жилийн төсвийн төсөлтэй хамтад нь боловсруулж, харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ",* 48.5-т *“Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ”* гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг шаардлагатай бол техник, эдийн засгийн үндэслэлийн хамт дараа жилийн төсвийн төсөлтэй хамт боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж байх зөвлөмж өгөв.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар *“Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай”* албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар хэмнэгдсэн зардлыг гүйлгэн зарцуулж, бодитоор тайлагнаагүй, өмнөх онд өр төлбөр үүсгэлгүйгээр тайлант оны төсвөөс шагнал олгосон болон анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой нийт 659,414.4 мянган төгрөгийн 7 зөрчилд албан шаардлага, зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 2 | 16,493.8 | 2 | 16,493.8 | 100 |
| Зөвлөмж | 5 | 642,920.6 | 5 | 642,920.6 | 100 |
| **Нийт дүн** | **7** | **659,414.4** | **7** | **659,414.4** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг тухайн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчлөөр тооцолгүйгээр дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Тус газарт ямар нэгэн албан тушаал эрхэлдэггүй, ажилласан эсэх нь цагийн бүртгэлээр баталгаажаагүй О.Ууганбаатарыг Сүхбаатар сум дахь гал түймэр унтраах 36 дугаар ангид аврагч-гал сөнөөгчөөр, Э.Эринг Сайхан сум дахь Гал унтраах 61 дүгээр ангид аврагч-гал сөнөөгчөөр, Э.Алтанхишигийг Хүдэр сум дахь Эрэн хайх, аврах салбарт аврагч-тэсэлгээчнээр тус тус ОБЕГ-ын даргын тушаалаар томилон батлагдсан цалингийн сангаас нийт **25,461.6** мянган төгрөгийн цалин тооцож олгосон байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Бараа материалын тайланд шатахууны үлдэгдлийг 17,952.4 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан алдааг аудитын явцад залрууллаа.

Аудитаар нийт 70,334.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 69,334.4 мянган төгрөгийн 6 зөрчилд зөвлөмж өгсөн.

### 5.1 Албан шаардлага.

*2.1 <u>Илрүүлэлт:</u>* Нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас 2 албан хаагчид **1,000.0** мянган төгрөгийн үнэ бүхий бэлэг, дурсгалын зүйл олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх *"Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно"*, 15.1.5: *"төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"* гэсэн заалтыг зөрчсөн байна.

*2.2 <u>Шийдвэрлэсэн нь</u>*: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал***

*1.1.1 <u>Илрүүлэлт:</u>* Бараа материалын орлого, зарлагын баримтыг холбогдох албан тушаалтнуудын гарын үсгээр баталгаажуулалгүйгээр ажил гүйлгээг гүйцэтгэж бүртгэл тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"*, 13.5 дахь *"Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно..."* гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.1.2 *Өгсөн зөвлөмж:* Бараа материалын орлого, зардлын анхан шатны баримтыг холбогдох албан тушаалтнуудын гарын үсгээр баталгаажуулж байх.

1.2.1. *Илрүүлэлт:* Тайлант онд нийт **67,385.7** мянган төгрөгийн хүнс, урсгал засварын материалын худалдан авалтын цахим төлбөрийн баримтыг нэр төрөл, тоо хэмжээ тус бүрээр бус бөөн дүнгээр баталгаажуулсан нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь *" ... Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. ..."* гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2.2 *Өгсөн зөвлөмж:* Худалдан авалтыг бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ нэг бүрийг тусгасан төлбөрийн цахим баримтаар баталгаажуулж байх.

**2. Мөнгөн кассын үйл ажиллагаатай холбоотой асуудал**

2.1 *Илрүүлэлт:* Тус газрын нярав С.Мөнхцэцэгийн хувийн харилцах дансаар дамжуулж албаны тээврийн хэрэгслүүдийн татвар, үзлэг оношилгооны төлбөр болох **1,948.7** мянган төгрөгийг зарцуулсан байгаа нь Сангийн сайдын 2012 оны 276 дугээр тушаалаар баталсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 3.1 дэх *"Төсөвт байгууллага нь Төрийн сангийн бүртгэлийн данснаас байгууллагын төлбөрийн картын дансаар дамжуулан бэлэн мөнгийг байгууллагын касст хүлээн авч зориулалтын дагуу зарцуулах үүргийг хүлээнэ"*, 3.2 дахь *"Мөнгөн кассын гүйлгээг байгууллагын төсвийн эрх захирагчийн тушаал, шийдвэрээр томилогдсон мөнгөн кассын нярав хариуцан гүйцэтгэнэ"* гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2 *Өгсөн зөвлөмж:* Бэлэн мөнгөний ажил гүйлгээг байгууллагын арилжааны банкин дахь картын дансаар гүйцэтгэх.

**3. Хөрөнгийн ангилал, бүртгэлтэй холбоотой асуудал**

3.1.1 *Илрүүлэлт:* Үндсэн хөрөнгийн шинж чанартай 38 нэр төрлийн хөрөнгийг бараа материалын дансанд, бараа материалын шинж чанартай 8 нэр төрлийн хөрөнгийг үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь "*Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*" гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.1.2 *Өгсөн зөвлөмж*: Хөрөнгийн ангиллыг стандартын дагуу үнэн зөв хийж, бүртгэл тайланд тусгаж, залруулах.

3.2.1 *Илрүүлэлт:* Албан хаагчдад тавьж олгосон нормын хувцас хэрэглэлийг тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй нь бараа материалын, улмаар хөрөнгийг үлдэгдлийг хий өсгөж, санхүүгийн тайланг бодитоор илэрхийлэхгүй байх эрсдэлийг үүсгэж байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар 1 дүгээр хавсралтаар баталсан *"Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"*-ын 4.21 дүгээр заалтын Г дэх *"Бараа материалыг ажил үйлчилгээнд ашиглахаар тавьж олгоход: Дт. Зардал /Зардлын зүйлээр/ Кт. Хангамжийн материалын холбогдох дэд данс"* гэсэн заалтыг зөрчсөн байна.

*3.2.2 <u>Өгсөн зөвлөмж:</u>* Албан хаагчдад тавьж олгосон нормын хувцсыг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэх, хөрөнгийн үлдэгдлийг үнэн зөв илэрхийлж байх.

**4.1 Санхүүгийн тайлантай холбоотой асуудал**

*4.1 <u>Илрүүлэлт:</u>* Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дахь *“Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна*”, 8.1.5 дахь *“санхүүгийн тайлангийн тодруулга”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

*4.2 <u>Өгсөн зөвлөмж:</u>* Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, онцлог байдлыг илтгэсэн тайлбар, тодруулгуудыг хийж байх.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан. | 1 | 17,952.4 | | | 1 | 17,952.4 | 1 | 17,952.4 | | | | |
| **Дүн** | **1** | **17,952.4** | | | **1** | **17,952.4** | **1** | **17,952.4** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй. | 1 | 1,000.0 | | | 1 | 1,000.0 | | | | | | |
| Орлого, зарлагын баримтыг гарын үсгээр баталгаажуулаагүй. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Төлбөрийн цахим баримтыг бөөн дүнгээр баталгаажуулсан. | 1 | 67,385.7 | | | | | 1 | 67,385.7 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Тавьж олгосон нормын хувцсыг зардлаар бүртгээгүй | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Мөнгөн кассын ажиллагааны журам зөрчсөн | 1 | 1,948.7 | | | | | 1 | 1,948.7 | | | | |
| Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн бэлтгээгүй. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| **Дүн** | **7** | **70,334.4** | | | **1** | **1,000.0** | **6** | **69,334.4** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансанд мэдээлбэл зохих мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 14 | - | | | | | 14 | - |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан боловсруулж, батлуулаагүй. | 1 | | | | | | 1 | - |
| **Нийт дүн** | **15** | **-** | | | | | **15** | **-** |